

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ТҮНТ-ИЙН 2021 ОНЫ
03 ДУГААР САРЫН 18-25-НЫ ӨДРҮҮДЭД ХИЙСЭН
АЖЛЫН МЭДЭЭ

7056311 төвд 31 дуудлага ирж төрийн үйлчилгээнд хамаарах 7 хүсэлтийг хүлээн авч АЗДТанилцуулагдсан. Шийдвэрлэж хариу өгсөн 2, шийдвэрлэлтийн шатандаа 5 байна.

Өргөдлийг утгаар нь авч үзвэл: Дадал суманд байрлах эмийн сангийн тусгай зөвшөөрлийг сунгахгүй 2 сар болж байна, холбогдох албаны хүмүүс нь ямар нэгэн хариу өгөхгүй байна, Аймагт бараа бүтээгдэхүүний үнэ, махны үнэ өсөж ард иргэдийн амьдралд хүнд байна, үнийн өсөлтөд хяналт тавих хэрэгтэй байна, Байгууллагууд үйлчилгээний стандартай болж соёл болон харьцаа сайжирч байгаа ч Дэлхийн зөнгийн харуул ёс зүйгүй харьцсанд анхааруулж өгнө үү, Нийтлэг үйлчилгээний газрын дарга ёс зүйгүй харьцсанд гомдолтой байна, Хэрлэн баян Улааны голын орчим малтай ихтэй айлдууд бууж голд үхэр үхэж, сэг зэмийг зайлуулахгүй байна, хог ачилтын дуудлага өгч хогоо хаяулах гэтэл нүүрсний хог авахгүй гээд дутуу ачаад байна, Өвс хамхуул их болж галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлж багийн дарга нар хяналтаа сайжруулж, цэвэрлэгээг сайн хийлгэнэ үү, гэсэн утгатай байна.

Өргөдөл гомдлын 1-р улирлын тайланг сумд, агентлагаас хүлээн авч, тайлан нэгтгэж байна.

ТҮНТөвөөр давхардсан тоогоор 1637 иргэн үйлчлүүлснээс: Улсын бүртгэлээр 147, ХХҮГазраар 87, Нийгмийн даатгалаар 200, ГХБХБГазраар 161, Татварын хэлтсээр 204, Архивын үйлчилгээгээр 3 хадгаламжийн нэгж 488 хуудас баримтанд тодорхойлон бичилт хийж 2 иргэнд зөвлөгөө өгсөн. Нотариат 134, Төрийн банкаар 278, Е хөтөчөөр 2, Операторын үйлчилгээгээр 4 лавлагаа олгосон, Брокер диллерээр 119, өөртөө үйлчлэх танхимаар 297, киоск машинаар 2 иргэн үйлчлүүлсэн.